# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Нарс шинэсэн төгөл” сум дундын ойн ангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/17/НА-СТА-ОНА**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс 7038 3793, Цахим шуудан khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас www.audit.mn

2024.03.11 № 01/940

танай ____________-ны № ____________-т

"НАРС ШИНЭСЭН ТӨГӨЛ" СУМ
ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА .МАРТ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Нарс шинэсэн төгөл" сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Нарс шинэсэн төгөл" сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд сумын орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 33,335.7 мянган төгрөгийн өртөг бүхий дулааны шугам сүлжээг хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 33,758.9 мянган төгрөгийн алдааг залруулж, зардлыг стандартад нийцүүлэн зөв ангилж бүртгээгүй, байгууллагын ашиглаж буй программ хангам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь байгууллагын онцлогт тохироогүй зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

**Бусад асуудлын хэсэг**

"Нарс шинэсэн төгөл" сум дундын ойн ангийн даргын Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ 90.4 хувьтай хэрэгжсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

9724040609

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/Төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 01-р сарын 01 | 12-р сарын 31 |
| А | Б | 1 | 2 |
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 38,372,937.37 | 66,175,756.76 |
| 1.1.4 | Дансны авлага | 1,792,500.00 | 20,440,800.00 |
| 1.1.7 | Бараа материал | 5,530,000.00 | 19,970,100.00 |
| **1.1.20** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **45,695,437.37** | **106,586,656.76** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | **61,684,167.08** | **94,865,865.81** |
| **1.2.1** | **Үндсэн хөрөнгө** | **61,526,167.08** | **94,861,865.77** |
| 1.2.1.2 | Барилга байгууламж орон сууц | 27,624,210.00 | 36,624,210.00 |
| 1.2.1.3 | Хуримтлагдсан элэгдэл | (12,726,189.00) | (15,868,349.05) |
| 1.2.1.4 | Авто -тээврийн хэрэгсэл | 65,828,500.00 | 39,919,410.00 |
| 1.2.1.5 | Хуримтлагдсан элэгдэл | (41,647,121.00) | (15,738,031.00) |
| 1.2.1.6 | Машин тоног төхөөрөмж | 33,323,527.80 | 31,583,935.80 |
| 1.2.1.7 | Хуримтлагдсан элэгдэл | (20,939,224.38) | (19,387,599.84) |
| 1.2.1.8 | Тавилга эд хогшил | 4,896,000.00 | 7,422,000.00 |
| 1.2.1.9 | Хуримтлагдсан элэгдэл | (2,584,843.17) | (1,524,256.14) |
| 1.2.1.10 | бусад үндсэн хөрөнгө | 19,817,413.00 | 37,368,396.00 |
| 1.2.1.11 | Хуримтлагдсан элэгдэл | (12,066,106.17) | (5,537,850.00) |
| 1.2.7 | **Биет бус хөрөнгө** | **158,000.00** | **4,000.04** |
| **1.2.20** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **61,684,167.08** | **94,865,865.81** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **107,379,604.45** | **201,452,522.57** |
| **2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| **2.1** | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | 3,746,252.00 |
| 2.1.1.6 | Бусад татварын өглөг | | 5,373,310.39 |
| **2.1.1.20** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **9,119,562.39** |
| **2.1.2.20** | **Өр төлбөрийн нийт дүн** | **-** | **9,119,562.39** |
| **2.2** | **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| 2.2.1 | Өмч : а) төрийн | 2,221,900.00 | 2,221,900.00 |
| **2.2.4** | **Хувьцаат капиталын дүн** | **2,221,900.00** | **2,221,900.00** |
| 2.2.7 | Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 33,280,950.80 | 31,830,546.00 |
| **2.2.8** | **Хуримтлагдсан ашиг (алдагдал)** | **71,876,753.65** | **158,280,514.18** |
| | өмнөх үеийн үр дүн | 71,876,753.65 | 123,587,704.45 |
| | Тайлант үеийн үр дүн | | 34,692,809.73 |
| **2.2.20** | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **107,379,604.45** | **192,332,960.18** |
| **2.3.20** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | **107,379,604.45** | **201,452,522.57** |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | өмнөх он | Тайлант улирлын дүн |
|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого /цэвэр/** | **149,359,133.00** | 198,210,500.00 |
| **2** | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 111,359,133.00 | |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **38,000,000.00** | **198,210,500.00** |
| **8** | Бусад орлого | 38,000,000.00 | 54,000,000.00 |
| **9** | Борлуулалт маркетингийн зардал | | 23,887,874.73 |
| **10** | Ерөнхий ба удирдлагын зардал | 76,125,630.00 | 97,195,065.00 |
| **11** | Санхүүгийн зардал | 648,000.00 | - |
| **12** | Бусад зардал | 39,049,330.13 | 96,434,750.54 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **20,458,653.62** | **34,692,809.73** |
| **19** | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **20,458,653.62** | **34,692,809.73** |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **20,458,653.62** | **34,692,809.73** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| | ҮЗҮҮЛЭЛТ | Хувьцаат капитал | Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг алдагдал | **Нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 2,221,900.00 | **33,280,950.80** | 51,418,100.03 | **86,920,950.83** |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | **2,221,900.00** | **33,280,950.80** | **51,418,100.03** | **86,920,950.83** |
| **11** | **2022 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл** | **2,221,900.00** | **33,280,950.80** | **71,876,753.65** | **107,379,604.45** |
| 12 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | 51,710,950.80 | **51,710,950.80** |
| **13** | **Залруулсан үлдэгдэл** | **2,221,900.00** | **-** | **123,587,704.45** | **125,809,604.45** |
| 14 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 31,830,546.00 | - | - | **31,830,546.00** |
| 18 | Тайлант үеийн цэвэр ашиг | | | 34,692,809.73 | **34,692,809.73** |
| **21** | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **34,052,446.00** | **-** | **158,280,514.18** | **192,332,960.18** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | өмнөх он | Тайлант үеийн |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн** | **149,359,133.00** | **233,562,200.00** |
| | Бараа борлуулсан үйлчилгээний орлого | 111,359,133.00 | 179,562,200.00 |
| | Татаас санхүүжилтийн орлого | 38,000,000.00 | 54,000,000.00 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн** | | **187,508,580.61** |
| | Ажилчдад төлсөн | 46,587,262.00 | 81,108,096.61 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 5,823,475.00 | 10,713,658.00 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | 5,642,350.00 | 55,212,990.00 |
| | бичиг хэргийн зардал | 1,250,270.00 | 1,119,500.00 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | 10,548,810.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 2,924,565.44 | 142,560.00 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 250,000.00 | 159,000.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 42,159,286.00 | 28,503,966.00 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **44,721,924.56** | **46,053,619.39** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **4,250,000.00** | **18,250,800.00** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 4,250,000.00 | 18,250,800.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(4,250,000.00)** | **(18,250,800.00)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **40,471,924.56** | **27,802,819.39** |
| **5.1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **13,696,352.81** | **38,372,937.37** |
| **5.2** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **38,372,937.37** | **66,175,756.76** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | 2023 оны төлөвлөгөө | 2023 төлөвлөгөөний гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого** | **48,000.0** | **54,000.0** |
| 2 | **Татаас санхүүжилтийн орлого** | **191,773.0** | **198,210.5** |
| 3 | **Орлого** | 239,773.0 | 252,210.5 |
| | **Зардал** | **150,870.1** | **127,920.6** |
| 1 | Цалин | 100,860.8 | 81,108.0 |
| 3 | НДШ | 10,768.8 | 10,713.6 |
| 4 | Албан томилолт | 21,160.0 | 21,014.0 |
| 5 | Тээврийн хэрэгслийн татвар | 99.0 | 99.0 |
| 6 | Тээврийн хэрэгслийн оншилгоо | 66.0 | 66.0 |
| 7 | Тээврийн хэрэгслийн даатгал | 250.0 | 159.0 |
| 8 | Шуудан холбоо, хэвлэл захиалга, интернэт | 360.0 | 225.0 |
| 9 | Бичиг хэрэг | 1,735.5 | 782.3 |
| 10 | Үнэт цаасны зарлага | 1,900.0 | 1,900.0 |
| 11 | Газар төлбөр | 20.0 | - |
| 12 | түлш шатахуун | 12,400.0 | 11,245.7 |
| 13 | Сургалт | 500.0 | 80.0 |
| 14 | аудитын зэрэглэл тогтоох | 450.0 | - |
| 15 | Санхүүгийн программын лиценз сунгалт | 300.0 | 528.0 |
| | **Засвар үйлчилгээний зардал** | **76,930.0** | **83,470.1** |
| 16 | Сэлбэг хэрэгсэл | 11,800.0 | 9,741.1 |
| 17 | Бусад бараа материалын зардал | 20,450.0 | 42,490.4 |
| 18 | Багаж тоног төхөөрөмж | 23,480.0 | 18,250.8 |
| 19 | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | 4,000.0 | - |
| 20 | Урсгал засвар | 17,200.0 | 12,987.8 |
| | **Ашиглалтын зардал** | **6,150.0** | **6,126.9** |
| 21 | Банкны шимтгэл | 70.0 | 273.4 |
| 22 | Түлээний үнийн хөнгөлөлт | 3,000.0 | 3,000.0 |
| 23 | Нэг удаагийн буцалтгүй тусламж, Шагнал | 700.0 | 650.0 |
| 24 | Түргэн элэгдэх бараа | 1,630.0 | 1,051.0 |
| 25 | Гэрэл цахилгаан | 750.0 | 1,152.5 |
| 26 | Хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,647.0 | 16,848.6 |
| 27 | **Зардлын дүн** | **233,950.1** | **217,517.6** |
| 30 | **Тайлангийн ашиг алдагдал** | **5,822.9** | 34,692.9 |

## 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,758.9 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд залруулаа. Үүнд:

1. ААНОАТ-т төлсөн 200.0 мянган мөнгийг банкны үйлчилгээний хураамжийн зардалд төлсөн алдааг залруулсан.
2. Татварын байгууллагад төлсөн болон банкны үйлчилгээний шимтгэлийн зардлын 278.0 мянган төгрөгийг орлого үр дүнгийн тайланд санхүүгийн зардлаар тусгасан алдааг залруулсан.
3. Эздийн өмчийн бусад хэсэгт 33,280.9 мянган төгрөг бүртгэлтэй боловч тус үлдэгдэл нь бодит бус, тодорхойгүй байсан алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6 зөвлөмж хүргүүллээ.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

*1.1 Илрүүлэлт:*

Ойн ангийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилахгүй бүртгэсэн байна. Энэ нь СТОУС -2 "Бараа материал"болон сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-тай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*

Зардлыг бүртгэхдээ борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бусад зардлыг зөв ангилан бүртгэх

**2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

*2.1 Илрүүлэлт:*

Байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж*

Стандарт, шаардлагад нийцсэн бодлогыг баримт бичгийг баталж мөрдөх

**3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

*3.1 Илрүүлэлт:*

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн дансны код нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж*

Зардлыг бүртгэхдээ борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бусад зардлыг зөв ангилан бүртгэх

**4. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

*4.1 Илрүүлэлт:*

Тус байгууллагын ашиглаж буй программ хангамж нь ашиглалтын шаардлага хангахгүй, тайлагналыг аж ахуйн нэгж байгууллагын загвараар бэлтгэхгүй байна.

*4.2 Өгсөн зөвлөмж*

Бүртгэл, тайлагналд ашиглаж буй программ хангамжийг байгууллагын онцлогт тохируулах шинэчлэх

5. **Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

*5.1 Илрүүлэлт:*

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хэмжээ 1,000.0 мянган төгрөг, санхүүгийн тайлан дах төрийн болон орон нутгийн эзэмшлийн дүн 2,221.9 мянган төгрөг байгаа ба 1,221.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дах заалттай нийцэхгүй байна.

*5.2 Өгсөн зөвлөмж*

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэх

6. **Шилэн дансны тухай холбоотой**

*6.1 Илрүүлэлт:*

Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тухайн жилийн зорилтот түвшинд орсон өөрчлөлт, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн *6.1.1.тухайн жилийн төсөв,* худалдан авах *ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;* гэсэн заалтуудтай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*6.2 Өгсөн зөвлөмж*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардлыг буруу бүртгэсэн. | 2 | 478.0 | | | 2 | 478.0 | | | | |
| Эздийн өмчийн бусад хэсгийг буруу бүртгэсэн. | 1 | 33,280.9 | | | 1 | 33,280.9 | | | | |
| Дүн | 3 | 33,758.9 | | | 3 | 33,758.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Зардлыг зөв ангилаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дансны код буруу | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Программ хангамж | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| шаардлага хангахгүй | | | | | | | | | | | | |
| НББББББ-гүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сангийн дүн зөрүүтэй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| ***Дүн*** | | | | | | | | |